

## САЛАА УТГА БҮХИЙ ТӨСӨӨТ ҮГ

*Б.Идэрбаяр, доктор, Эрдэм Их Сургууль***Abstract**

This article reviews some recent publications dealing with the phenomenon of polysemy, and addresses some of the questions which they raise. According to a generally accepted definition, polysemy is the association of two or more related senses with a single phonological form. In many respects, the definition is highly problematic. Important foundational questions concern the nature of word senses, how they can be identified, enumerated, and characterized, the manner in which they may be related, and the psychological reality of these constructs. A further question concerns the kinds of linguistic units that are candidates for a polysemy analysis. Also not to be overlooked is that fact that the phonological pole of a linguistic unit is likely to exhibit variation no less than the semantic pole. In spite of the many theoretical and descriptive problems associated with polysemy, it is remarkable that speakers of a language are rarely troubled by it. The paradox is traced back to way in which polysemy is conceptualized by linguists, against the backdrop of ‘idealized cognitive models’ of language. The article concludes with some observations on a usage-based approach to issues raised. This article outlines the challenges relating to the lemmatization of the lexical items which are either polysemous or homonymous. These problems can be ascribed to a lack of objectivity resulting from an inadequate knowledge regarding the etymological relationships of the meanings of some lexical items which are subsequently misclassified as either homonyms or polysemous words. This often causes improper lexical entries in dictionaries, i.e. polysemous words may be lemmatized as homonyms and vice versa. To unambiguously distinguish between lexical items which are either homonyms or polysemous words, lexicographers should in this regard consider the criteria suggested by scholars: -In accordance with the relatedness/unrelatedness criterion, the lexicographer will need to determine the extent to which the lexical items are related before entering them in the dictionary. The etymological criterion will help the lexicographer to determine the relatedness of the lexical items for inclusion in the dictionary according to their historical connection. Using these criteria to lemmatize a lexical item properly in the dictionary, the lexicographer will be required to determine whether a lexical item can be regarded as one word with more than one meaning (a polysemous word), or as two different lexical items which have the same spelling (homonyms). To make this distinction, the lexicographer will need to research the historical background of the lexical item. Even though these criteria are important aids for distinguishing polysemy and homonymy, the problem of subjectivity is not altogether removed since the criteria do not specify the level or degree of relatedness/unrelatedness at which the lexical item(s) can be said to be polysemous or homonymous.

**Түлхүүр үг**

Салаа утга бүхий төсөөт үг, салаа утгатай үгсийн утга хоорондын харьцаа, ижил утгатай үг, авианы хэлбэр

Салаа утга нь нэгэн үгийн салмал олон утгын харьцааг илтгэх үгийн сан-утгазүйн ай юм. Утга судлалын түвшний бага нэгж бол нэгжээд утга /моносема/ юм. Салаа утгат үгийн аль нэг нь нэгжээд утга болно. Ийм нэгжээд утга нь үгийн хэрэглээний үр дүнд бий болдог байна. Нэг үг олон утгатай болоход цөм утга нь олон аргаар салбарлан баяждаг нь зүй юм. Утгын тооны хувьсал нь салаа утгыг бүтээдэг байна. Салаа утгын айн уг чанар нь нэг үгэнд олон утга байх зарчим юм. Нэг үг цөм утгаас гадна хэд хэдэн салаа утгатай байж болно. Салаа утгатай байх нь төсөөт үгийн хагас тохирох шинжтэй ойролцоо юм. Харин цөм утгатай байх нь төсөөт үгийн голлож хэрэглэгддэг үгийн шинжтэй адил юм. Цөм утга нь салаа утгыг өөртөө агуулж байдаг гол үг юм. Төсөөт үг нь салаа утгатай байх нь ерийн хэлнүүдийн бүтцийн ердийн шинж биш

юм. Гэвч хэлний нэгжүүдийн олон утга хөгжихгүй байх зүй тогтол үгүй юм. Учир нь хэлний нэгжүүдэд хязгаартай тооны нэгжээр арай олон тооны утгыг хэмнэлттэй илтгэх боломж олгодог байна. Энэ үзэгдэл “нэг үгэнд (энэ нэгжид илрэх) хоорондоо холбоотой хэд хэдэн утга байдаг”-аар илэрдэг байна. [СЛТ, 1986:235]

Авиа зүйн түвшинд салаа утга бүхий төсөөт үгс /ижил үг мэт/-ийн хувьд хэлбэрийн ерөнхий шинж гол шалгуур нь юм. Салаа утга бүхий төсөөт үгийн агуулгын бүтцэд нь “утгын ерөнхий хийсвэр ойлголт” байдаг. Салаа утгатай үгс “бодит утга /реляционноезначение/ илтгэж чаддаг” байна. Түүний олон утга нь өөрийн агуулгаар бодит ерөнхий хэсэгтэй байдаг. Ийм утгын ерөнхий бүрэлдэхүүн нь салаа утгатай үгсийг төсөөт үгтэй ойртуулдаг. Учир нь салаа утгатай үгсийн утга нь

хоорондоо янз бүрийн харьцаанд оршиж байдаг. Нэг үгийн утгын бүтцэд хам сэдвээр бүрэлдсэн ерөнхий бүрэлдэхүүний хэлбэрээр бусад бүх утгад ордог хам сэдвээр бий болоогүй үндсэн утга ялгардаг.

Аливаа нэгэн юм, үзэгдлийн адил төстэй талыг нөгөө юм үзэгдлийн онцлох шинж болгон жишиж, утгыг шилжүүлэн нэрлэдэг. Салаа утгат үгийн гол хэв шинж нь олон талаараа төстэй байж болох учраас хэсэг нь бүхэлдээ харьцах харьцаа буюу тэдгээрийн байрлал, дүрсийн онцлогоор утга шилжүүлэн нэрлэх явдал юм. Жишээ нь, *АржГАР-БуржГАР-ЭржГЭР, АржИЙХ-ЭржИЙХ, АрзайХ-БарзайХ-БУрзайХ-СарзайХ-ХорзойХ-ХөрзийХ\ГАНХ\ЛЗаХ\, Арзан-Барзан-Бурзан-Сарзан-Хорзон, Арзгай-Барзгай-Сарзгай, Арзгар-Барзгар-Бурзгар-Сарзгар, АрСайХ-арЗайХ-БарСайХ-ДарСайХ-ДорСойХ-ОрСойХ-СарСайХ\ГАНХ\ЛЗаХ\.*

*Арсгар-Барсгар-Дарсгар-Сарсгар-Эрсгэр, Архай-Дархай-Тархай, АрхайХ-ДархайХ-ТархайХ\ГАНХ\ЛЗаХ\, АрхуРАА-архуРАЛ\т\ХархирАА, АрхуРАХ-БарХуРАХ-ХархуРАХ-ХаШХуРАХ* гэх мэт авиа дуурайх болон дүрс дуурайх үгс нь олон талаар төстэй ч, бүр цаашилбал, авиа дуурайх үг болон дүрс дуурайх үг ч хоорондоо холбоотой нь дээрх жишээнээс харагдаж байна. Монгол хүний сэтгэхүй, сэтгэлгээний болон амьдралын онцлогоос шалтгаалан үгийн цөм утга салаалж, өөрөөр хэлбэл, хөдлөл, хэлбэр, дуу авиаг дуурайлган нэрлэдэг нь монгол хэлний, тэр дундаа салаа утга бүхий төсөөт үгийн гол онцлог юм.

Салаа утга бүхий төсөөт үгийн цөм утгаас салсан бусад утгыг өмнөх хойдох үг буюу хам хүрээллээс мэдэж болдог. Жишээ нь, *шавайх-шовойх-шөвийх-сэвийх-сээвийх-сөвийх-сөөвийх-овойх-өвийх-өөвийх, адайр-хэдэр, ундуй-сундуй, энх-мөнх, ааш-ааль*

Эдгээр дүрслэх үгээс үүссэн салаа утга бүхий төсөөт үгс нь хэлний тогтолцоогоор бүрэлддэг байна. Утгын цараа нь хоёр ойролцоо утгын хооронд л төстэй байдлаар илэрч, захын утгуудынх нь алдагдахаар тийм их байдаг. Жишээ нь, *шавайх /эхний/-өөвийх /сүүлийн/ г.м.*

Иймэрхүү үгсийн агуулгын бүтцийг задлан шинжлэхэд сүүлдээ эдгээр утгыг нэг ерөнхий утгын хувилбар гэж ойлгоход хүргэдэг байна.

Ижил дуудлагатай үгэнд ойролцоо үг олоход тэдгээр үг хоорондоо утгын холбоотой байвал салаа утга бүхий төсөөт үг болно. Жишээ нь, *царайх-цэрийх* гэдэг үгсэд *цоройх-цүрийх* гэдэг үгсийг сонговол салаа утга бүхий төсөөт үгс болох юм. Түүнчлэн холбоо үг үүсгэн /синтагматик статус/ шалгавал салаа утга бүхий төсөөт үгийг

илрүүлж болох юм. Жишээ нь, *гэдэс царайх-цэрийх-цоройх-цүрийх* гэх мэт.

Хэрэв эдгээр аргаар илрэх боломжгүй бол үгийн гарлаар нь тогтоох байдлаар ялгаж болох юм. Жишээ нь, *энх-мөнх* гэхэд тэргүүн үеийн гийгүүлэгч сугарч, *√*нг оруулбар /инфикс/ орж үүссэн үг болно.

Мэдээж, хэлэхийн хэрэглээнд салаа утга алга болдог ч салаа утга бүхий төсөөт үгийг тогтвортой, тогтворгүй ойролцоо үгийн хэлбэрээр хэрэглэж болдог байна. Жишээ нь, *ундуй-сундуй, энх-мөнх г.м*

Авиа ба дүрс дуурайх үгс нь хам цагийн үүднээс бие даасан үгс болох ба цуваа цагийн үүднээс уул үгсийн хувилбар болно. Анх эдгээр үгсийн авиалбарын сэлгэц нь саармагжиж, дундын шинжтэй байснаа уул авиалбарууд ялгарч, төсөөт утга бүхий үгс бий болжээ.

Т.А.Бертагаев (авиа ба) дүрс дуурайх үгийн сэлгэмэл авиалбарыг бүрэн бус авиалбар (авианцар=фонемойд) хэмээн үзсэн нь саармагжих ёстой холбогдоно (Бертагаев, 1974. х.263). Иймээс *данхайх~донхойх~дунхайх~дэнхийх~дүнхийх ба ян ён, ен, ён, е(ө)н е(и)н* зэрэг үг нь утга нь ч хагас, авиа нь ч хагас тохирох тул ойролцоо үг ч биш, үг буюу нэрлэврийн хувилбар ч биш юм. Иймээс ийм үгсийг эрдэмтэн Базаррагчаа утга болон авианы найруулгын холбогдол бүхий сэлгэц хэмээн үзсэн билээ. Гэхдээ зөвхөн авианы хол ойрын сэлгэцээр ялгахыг оролдсон байна.

Эдгээр үгийн сэлгэцийг Т.А.Бертагаев “багц сэлгэвэр” (пучкичередования) гэж нэрлэсэн билээ. Үгийн эхний гийгүүлэгчийн сэлгэх, улмаар гээгдэн, үе-утгалбар задгайрах тухай дэлгэрэнгүй өгүүлсэн бөгөөд *алусбулус* (үр ач нараа алагчлан хайрлах) *-а-лу-с* (алс-хол), *а-ла-г бу-ла-г* (алаг булаг), *а-ла-нгса-ла-нг* (алан-салан), *а-ла-н* (алаг-тахь), *ку-ла-н* (хулан-алаг хонгор зүс), *ко-ла* (хол), *та-ла* (тал) зэрэг үгийн эхэнд “*б-к-с-т*” гэсэн гийгүүлэгч сэлгэж байсан ба эдгээрийн гол утга нь (салах-холдох-алаглах) гэсэн утгатай юм. Эдгээр нь “*халхайх, холхойх, хэлхийх, хөлхийх, хулхийх, балхайх, болхойх, булхайх, бялхайх, бэлхийх, бүлхийх, бөлхийх, салхайх, сулхайх, сэлхийх, сүлхийх, талхайх, тулхайх*” зэрэг дүрслэх үгээс эхтэй юм.

Хүн юмсын тодорхой шинжид тулгуурлан, утгыг шилжүүлэн салаалуулж нэрлэдэг. Т.Пагва “Үгийн утгыг зүйрлэн хэрэглэхэд нэрлэгдэх юм нь өөрчлөгдөх боловч ухагдахуун нь өөрчлөгдөхгүй юм” (Т.Пагва. 1959, х.87) гэсэн нь нэр өөрчлөгдөх боловч цаад ухагдахуун нь өөрчлөгдөхгүй, харин тэр ухагдахууныхаа утгыг улам дэлгэрүүлж өгдөг болохыг өгүүлсэн хэрэг юм. Жишээ нь,

*Болцгор-бУлцгар-бУлцгэр-бЭлцгэр, БОлцойХ-бУлцайХ-бУлцийХ\ГОНОХ\ЛЗОХ\, БОлцуу-бУлцуу-бЭлцрүү, БОмбойХ-бӨмбийХ\ГОНОХ\ЛЗОХ\, БОмбогор-бӨмбөгөр-бУмбагар-Омбогор-Өмбөгөр, БОНдгор-бӨндгөр-Ондгор-Өндгөр, БОНдойХ-бӨндийХ-бУндайХ-ОндойХ-ӨндийХ\ГОНОХ\ЛЗОХ\* Нэг язгуураас үүсэн нэг үсгийн аймагт багтаж утга хэлбэрээрээ хагас тохирох үгсийг төсөөт үгс гэдэг бол мөн нэг үгсийн аймагт багтаж утга хэлбэрээрээ хагас тохирох загвар бүтээвэр байж болох ажээ. Үүнийг төсөөт загвар гэж болно. Жишээ нь,

-р-ка-у (-р-хуу) – р-ка-г (-рхаг)

-ла(-л) л-да (-лд) ба (өсүгэйлэ-өсүгэйилдэ-өсүгэйидэ-)

-ма-га-и ма-га-га-и (түрэмгэй-түримэтэгэн аймаг\кашайматаган)

Эдгээр залгавар нь салаа утгаас үүдэлтэй юм. Жишээ нь, тэмдэг нэр бүтээх *р-ка-г-р-ка-у* (-р-ка-гу) хоёр нь *ка-гу* гэсэн нийлмэл залгаврын “г” нь гээгдсэн эсэхээс шалтгаалан “г”-г тухайн юмны “элбэг шинж” нь тодорхой гэсэн утгыг Монгол хэлний нөхцөлгүй үг нь дүрслэх ба авиа дуурайх гэж хоёр янз бөгөөд (Базаррагчаа, 1987, х.85) ялангуяа, авиа дуурайх үгс нь хатуу шингэн аль боловч биеийн дуу чимээ хүний чихэнд адил сонсогдох учраас салмал олон утгатай байна.

Жишээ нь, *хор хор* гэх авиа дуурайх, нөхцөлгүй үг нь:

1. Усны чимээ: Горхийн ус *хор хор* хоржигнож, голын ус *хор хор* урсах,
2. Амьтны хоолой: Хоолой нь *хор хор* дуугарах
3. Хонх *хор хор* дуугарах (Цэвэл. 1966. х.693)

шар шар хийх авиа дуурайх, нөхцөлгүй үг нь:

1. Цасны чимээ: *шар шар* хийх чимээ гарган явах
2. Цаасны чимээ: *цаас шар шар* хийн дуугарах

Хатуу биетийн чимээ: хадан дээр *шар шур* хийн дуугарах гэх байдлаар ангилж болох ба *хоржигнох-харжигнах-хүржигнэх-хуржигнах, шаржигнах-шоржигнох-шуржигнах-шөржигнөх* гэсэн авиа дуурайх утгатай салаа утга бүхий төсөөт үг үүсэх суурь болдог байна. Учир нь авиа дуурайх үгийг шар шар, хор хор гэх мэтээр давтал тухайн чимээ үргэлжлэх үйл болж – *жи+гна<sup>3</sup>*-дагавраар төсөөт үгс үүсч байна. Жишээ нь, *Харжиг-хОржиг, ХаржигНаХ-хОржигНоХ, ХарзайХ-АрзайХ-хОрзойХ-хӨрзийХ\ГАНХ\ЛЗАХ\, Харзгар-Арзгар-хОрзгор-хӨрзгөр* гэх мэт. Эндээс ажиглахад, авиа дуурайх үгээс үүссэн салаа утгат төсөөт үгсийн бүтэх гол арга нь *-г(а)<sup>4</sup>, -гна<sup>4</sup>* гэх мэтийн дагавраар, харин дүрслэх үгээс үүссэн салаа утга бүхий төсөөт үг нь *-гар<sup>4</sup>, -ж, -з+ий-* гэсэн загвар дагавраар үүсдэг байна. Жишээ нь, *Төвгөр-Овгор-өвгөр-тОвгор, ТөвийХ-ОвойХ-ӨвийХ-тОвойХ\ГНӨХ\ЛЗӨХ\* гэх мэт. Харин дүрс дуурайх үгээс үүссэн төсөөт үгс нь *-х, -с, -л* дагавар авч утга салаалдаг байна. Жишээ нь,

зааж байгаа бол “г”-гүй нь тухайн юмны “элбэг шинж” нь тодорхой бус, таамагласан байдалтай ажээ. Хэдийгээр эдгээр нь утгын ялимгүй ялгаатай боловч салаа утгаас үүссэн бүтээврийн хувилбар уу, эсвэл салаа утгаас үүсэж, улмаар утга нь холдсон төсөөт үг үү гэдэг нь ихээхэн ярвигтай зүйл юм.

-э-мэ-г-чи-н-(эмэгчин) э-мэ-г-тэ-и(эмэгтэй)э-мэ-г-тэ-н(эмэгтэй)

-э-рэ-г-чи-н-(эрэгчин) –э-рэ-г-тэ-и(эрэгтэй) –э-рэ-г-тэ-н(эрэгтэй)

-ка-ту-н-та-н (хатантан)~(хатагтай)

-би-чи-гэ-чи(бичээч)~би-чи-г-чи(бичигч),су-би-ла-га-чи (сувилаач)~су-би-ла-г-чи (сувилагч), у-ду-ри-д(у)-г-чи (удирдагч), у-ду-ри-д(у)га-чи (удирдаач), бай-йи-л-ду-г-ч (байлдагч)~бай-йи-л-ду-га-н-чи (байлдаанч)~ба-йи-л-ду-га-чи (байлдаач); нэ-рэ-тү (нэрт)~нэ-рэ-тэ-и (нэртэй),~нэ-рэ-тэ-н (нэртэн); то-бу-ча-г (товцог)~то-бу-р-ча-г (товорцог)~до-бу-ча-г (довцог) гэх мэтээр дагаврыг харьцуулан, төсөөт залгавар бий эсэхийг нягтлах нь чухал болжээ.

*Товхгор-тӨвхгөр, ТовхиЛоХ-товхиХ, ТовхойХ-тӨвхийХ\ГОНОХ\ЛЗОХ\* Монгол хэлний дүрслэх үг бол долоон эгшгийн ёсоор утга ялгах сэлгээгээр үүсч, нэгэн цөм утгаас салаа утгууд үүсдэг байна. Дүрслэх язгуурын бүтцэд долоон ург, богино эгшиг сэлгэж утга ялгадаг байна. Жишээ нь,

*БАНдага-бОНдого-ПАНдага, БАНдайХ-бОНдойХ-бӨндийХ-бУндайХ-ПАНдайХ\ГНАХ\ЛЗАХ\, БАНдгар-бЭндгэр-бИНдгэр-бОНдгор-бӨндгөр-бУндгар-бҮндгэр-/7эгшиг/ ПАНдгар-пУндгар, БАНдгас-бОНдгос-ПАНдгас, БАНхайХ-бОНхойХ-бҮнхийХ\ГНАХ\ЛЗАХ\, БАНхгар-бҮнхгэр, СагсайХ-сЭгсийХ\ГНАХ\ЛЗАХ\ Сагсарга-сЭгсэрэг, СагсаргаЛаХ-сагсаргаТаХ, Сагсар-сЭгсгэр-сОгсгор-сӨгсгөр-сУгсгар-сҮгсгэр/6 эгшиг/, ХалхайХ-хЭлхийХ-хОлхойх-хУлхайх-хҮлхийх\ГНАХ\ЛЗАХ\ /5 эгшиг/, Халхгар-хЭлхгэр\ДУУ\ХАН\, СарсайХ-АрсайХ-сЭрсийХ-ЭрсийХ\ГНАХ\ЛЗАХ\, Сарсар-Арсгар-сЭрсгэр-Эрсгэр, Сартага-сЭртэг*

*СартайХ-сЭртийХ-сОртойХ-сӨртийх\ГАНХ\ЛЗаХ\ /4 эгшиг/, Сартгар-сЭртгэр,Сархгар-сЭрхгэр, Сархиа-сархиаГ-сЭрхээ-сэрхээГ, Сархиаг-сархиаГ, Сарчгар-сЭрчгэр, СарчийХ-сЭрчийХ\ГАНХ\ЛЗаХ\, Янхайх-Енхийх-Ёнхойх /3 эгшиг/,Сарайх-сЭрийх /2 эгшиг/*

В.Фон. Гумбольдт ухагдахуун тэмдэглэх гурван аргыг тодорхойлжээ.


Үүнд:

1. Алив юмын дуу чимээг шууд дуурайх арга. Тэгэхдээ салангид авиаг нийлүүлж хэлэх чадвартай учраас тэр нь үг болдог.
2. Авиа буюу юм хоёрт бус, харин тэдгээрийн дотоод уг чанарыг нь дуурайх арга. Үүнийг ухагдахуун тэмдэглэх бэлгэдлийн арга гэж болно. Үүний тул юмыг тэмдэглэхдээ тухайн авиаг сонгох ба юмнаас төрсөн сэтгэгдэл нь санааны гүнд бий болж байдаг. Жишээ нь, *stehen, statig, star* /зогсох, үл хөдлөх, тогтох/ зэргээс зогсонги байдлыг сэрж мэдэрнэ. Самгарди хэлний “*Li*” /хайлах, урсах/ нь “урсах” санаа төрнө. Мөн “*nicht, naden, nejd*” /үгүй, өлсөх, атаархах/ нь “огцом тасалдах” гэсэн сэтгэгдэл төрнө. Энэ нь олон хэлэнд адил төстэй байдаг.

3. Төстэй утгатай үгс нь төстэй авиагаар илрэх арга. Үүнийг бүрэн зохицсон аналог /төсөө/ гэж болно. (Гумбольдт, 1984, х.90-94) гэж үзсэний эхнийх нь мэдэгдэхүүн буюу авиа утга хоёр бодит шинжээрээ тохирохтой, дараах нь хэлэхүүн буюу хүн авианы шинжийг бүтээлчээр ухаарах ба эцсийнх нь хэлэгдэхүүний талаас авиа утга хоёрын ижил харьцааг анхаарахтай тус тус холбогдоно гэж бодож байна. Жишээ нь, *čar* (цар), *čer* (цэр), *čur* (цур), *čor* (цор), *čūr* (цүр) гэсэн авиа дуурайх үгийг *čar čar; čor čor* гэх мэтээр давтан хоршиж болох ба “*ki-, keme-, ge-*” үйл үгийн өмнө орох ба “*ča...*” нь “-г”-ийг алгасан давтаж, *ča-r-ča* (царцаа) хэмээх үг бүтжээ. “*ča*” үе-утгалбарыг хаасан “-r” нь “доргин чичрэх” утгыг илтгэдэг нь царцааны далавчны хөдөлгөөнийг дуурайжээ. “*č*” нь нимгэн хатуувтар юмны дуу чимээг илтгэдэг нь *čarčayi*-(царцайх), *čerčeyi*-(цэрцийх), *čargi*-(царгих), *čarkira*-(цархирах), *čar* (цар-цасан дээр өнгөлөн хөлдсөн мөс), *čar* (цар-бүрээс, бохь, цаваг наах ээдэм), *čar* (цар-овор байдал) зэрэг үг бүтээх суурь болжээ. Мөн *čarayi*-(царайх), *čereyi*-(цэрийх), *čoryi*-(цоройх), *čūrūyi*-(цүрийх) гэсэн дүрс дуурайх үг ч дээрхтэй язгуур гарал нэг болно. Энэхүү “*ča*” үе-утгалбар нь “нимгэвтэр юмны хатуурах нь уг биетийн тал бүрд тархмал байдаг” гэсэн бэлгэдлийн утгаас “цар хүрээ, цараа (*čar, čar-a*)” гэсэн утга салаалжээ. Монгол

хэлний үе-утгалбарын ерөнхий гол утгыг дараах байдлаар гаргаж болно. Үүнд:4.

1. ва~ра... “төвөөс зугтах”



та...”төвд тэмүүлэх”

2. da...”босоо чигт уртсах”



та... “хөндлөөшөө уртсах”

3. га...”хуурай юмын дээшлэх”



ла...”нойтон юмын доошлох”

4. qa...”нэлэнхүйдээ томрох”



(бүхэл)

ya...”ялгаран жижигрэх”

(хэсэг)

5. sa...”салж сарних”

(эвдрэх)



ла... “нэг чигт шулууудах”

па... “нийлж нягтрах”

(бүтэх)

6. со...”зүг зүгт цацрах”


s

ja... “нэг чигт салах”

ng

“байнгад үргэлжлэх”

ya... “нэг чигт тахийх”



Эдгээр 16 үе-утгалбарын утгыг хураавал “эвдрэх бүтэх” гэсэн дөрвөн үе-утгалбарт багтана. Энэ нь “*p`a...~q`a...*” (бүтэх) “*ta...~sa...*” (эвдрэх) дөрөв болно. Эдгээрийн сул хувилбар нь гэвэл, “*ba...~ya...*”(бүтэх), “*da...~na*” (эвдрэх) болно. Энэхүү чанга сул найман үе-утгалбараас бусад найман үе-утгалбар сэлгэцээр үүснэ. Жич. “*na...*” үе-утгалбарын эгшиг нь гээгдсэнээс “-ng” гэсэн гийгүүлэгч-утгалбар үүссэн нь өвөрмөц юм. Энэ тухай “Зүрхний толт”-ын тайлбарт” АН үсэг (ng) толгой үл болох нь, толгойлж монгол үг үл болоод тийн атал шинэ төрсөн нялхын дууны аялгууд буйн тул дэвсгэр болгогдохуй. Үлгэрлэвээс, нялхас “ИНАН” хэмээн уйлах мэт болой. Үгийн дэвсгэр болох нь амгалан жаргалан (*amuyulang, jiryalang*) гэжээ. Ийнхүү “эвдрэх ба бүтэх хоёр утга нь дөрөв болж, дөрөв нь найм болж, энэ чанга сул найман үе-утгалбараас “*ma, ča, ja, (či, ji), ša, ya, ng*” гэсэн мөн найман үе-утгалбар үүсэн, арван зургаа болж, үүнийг “*a, ĩ, u, e, I, ū, o, ǒ*” найман эгшгээр амилуулбал 128 үе-утгалбар үүсэх ба үүнийг эр эмээр ялгавал 64 болно.

	Дүрс дуурайх үг бүтээх нь		Авиа дуурайх үг бүтээх нь
1.	-ya: arja-ya, derči- ge, ūrči- ge -ya- r: arja- ya-r, derči- ge- r, ūrči- ge- r -ya- na: ija- ya-na-, gil- (ta)- ya- na-	1.	-gi: љуу- gi-, ља- gi-, tur- gi, qar- gi-, o-gi- -gi- r: qang- gi- r, jing- gi- r, (mang\gi-r) -gi- na: yang- gi- na-, dang- gi- na-, (song- gi- na)
2.	-ki: tal- ki, qol- ki-, al- ki-, (ol- ki- ya)	2.	-si: šab- si-, qob- si-, dab-si-, tūg-si-
3.	-l- ja+(ya- na-): gila- l- ja-, tobu- l- ja-	3.	-ji-gi-na: qa- r- gi- na-
4.	-yi-: obu- yi-, ōlo- yi-, kilu- yi-	4.	(-si-) ra: ља- si- ra-, љib- si- re-
5.	-s-: sarba- ski-, čorbu- s ge-, jireski-	5.	-d-: šar- d ki-, jardki-, tūrdge-, pulki-
6.	-ba+lja-, ar-ba- lja-,er- be- l-je-	6.	-ki- ra-: ber- ki- re-, qos- ki- ra-, būr-ki- re-
		7.8.	-la: oru- la-, čar- la- -tuna-: baba- tu- na, љуу- ki+(tu- na-)

Энэ хоёр бүлэг дагаврыг харьцуулбал “ya~ gi~ ki~ yi~ si, na, l, ja, ra, tu, ba...” гэсэн үе-утгалбар давтагдан орсон байх ба дээр дурдсан, бүхэлдээ хэсэг нь “багтах” утгатай “ki-” (хийх) - “-ki-”, мөн түүнээс сэлгэсэн “онцлон ялгах” утгатай “ya ~ gi”, үүнээс сэлгэж үүссэн, “байнгад үргэлжлэх” утгатай “-yi” үе-утгалбар чухал үүрэгтэй оролцсон байна. “Нэг юм нөгөөдөө багтах, орох” гэсэн утгатай “ki” нь “нэг зүйл нөгөөд шигэж шааж орох” гэсэн утгатай “si”-гээр сэлгэж, “*tob- ki-* (товхих), *tōb- ki- ne-* (төвхнөх), *tob- ki- ma- l* (товхимол)” хэмээх үг бүтэж, улмаар “ki” нь “*či*”-тэй сэлгэж, *tob-či* (товч), *tob- či- ya- n* (товчоо-н), *anibki-* (анивхийх), *anibči-* (анивчих) зэрэг үг бүтээнэ.

“CV” (гийгүүлэгч эгшиг)-ээс бүтсэн үе-утгалбар буюу Ц.Б.Цыдендамбаевынхаар үе-утгалбар нь өөр хоорондоо зэрэгцэн хоршиж, нийлмэл буюу хэлц дагавар бүтээдэг нь авиа ба дүрс дуурайх үгэнд ч, нэршсэн үгэнд ч тохиолдох болсон байна. Тухайлбал, авиа ба дүрс дуурайх үгсийн үе-утгалбар нь Л.Ш.Шагдаровынх шиг бусад буюу нэршсэн үгнээ тохиолдохгүй биш, харин ч түүнээс үүсэж утга хувирсан байдлаар тохиолдоно. Авиа ба дүрс дуурайх үгс нь монгол хэлний үг үүсэх эх булаг болдог дээрх хоёр бүлэг дагавраас олон дагавар нөхцөл, сул баймжит болон утгвар бүтээврүүд үүсчээ.

## Дүгнэлт

Ийнхүү монгол хэлний авиа ба дүрс дуурайх үгсийг утга хэлбэрийн талаас судалсаар ирсэн ба эдгээр үг нь монгол хэлний үгийн гарлыг тайлах түлхүүр болох төдийгүй, жинхэнэ монгол үгийн гарлын санг бүрдүүлэх чухал үүрэгтэй болно. тайлах түлхүүр болох төдийгүй, жинхэнэ монгол үгийн гарлын санг бүрдүүлэх чухал үүрэгтэй болно.

## Ашигласан материал

- Базаррагчаа, М.(2005). Хэлбэр утгын хөрвөл. МУИС., МХСС., “Монгол судлал” XIV боть. В  
Бертагаев, Т.А. (1969). Морфологическая структура слова в монгольских языках  
Бертагаев, Т.А. (1974). Лексика современных монгольских языков. Москва  
Гумбольдт, В.фон. (1984) М. Избранные труды по языкознанию  
Идэрбаяр, Б. (2005). Монгол хэлний төсөөт үг. Улаанбаатар  
Кацнельсон, С.Д. (1965). *Содержание слова, значение и обозначение*. Москва: Ленингр: Отд-е  
Кузнецов, А.М. (1980). Структурно-семантические параметры в лексике. Москва: Наука  
Пагва, Т. (1959). Хэл шинжлэлийн удиртгал  
СЛТ. (1986) Словарь лингвистических терминов  
Цэвэл, Я. (1966) Монгол хэлний товч тайлбар толь. Уб  
Федотова, Л.Н. (1988). Паронимия в современноманглийском языке: Автореф. дисс.канд. фил.наук.-  
Минск  
Якобсон, Р. (1975). Лингвистика и поэтика // Структурализм: “за” и “против”. Москва: Прогресс